



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

19 98 оны 4 дугаар
сарын өдөр

Дугаар А 72

Улаанбаатар
хот

Төрийн байгууллагын зарим чиг үүргүүдийг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх тухай

Нэг. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас төрийн бус байгууллагуудтай хийсэн гэрээг үндэслэн нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт заагдсан төрийн байгууллагуудын зарим чиг үүргүүдийг шилжүүлэн гүйцэтгэхэд шаардлагатай хавсралтанд заагдсан арга хэмжээний зардал 16 сая 526 мянган төгрөгийг нэр бүхий төрийн бус байгууллагуудад олгохыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн хэлтэс И.Гонгор-т зөвшөөрсүгэй.

Хоёр. Төрийн бус байгууллагуудтай хийсэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж, гүйцэтгэлийг хагас бүтэн жилээр дүгнэж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс И.Хадхүү-т даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ж.НАРАНЦАЦРАЛТ



Нийслэлийн Засаг даргын 1998 оны 79 дугаар тоот захиралжийн хавсралт

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД ГҮЙЦЭТГЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ

№	Төрийн бус байгууллага	Төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ	Зардлын хэмжээ
1	Хотын эмэгтэйчүүдийн зөвлөлөөс	Эдийн засаг, эрүүл ахуй, сурган хүмүүжүүлэх сургалт явуулах, зээл авагчдын зөвлөлгөөн хийх, ажиг үйлдвэрлэл зохиох ажлын байр бий болгох	5 сая.төг
2	Архи тамхиа нь хоороос иргэдээ хамгаалах нийгэмлэг	Архи тамхинаас сэргийлэх талаар судалгаа, сурталчилгаа, хэлэлцүүлэг сургалт явуулах	800 мян.төг
3	Хотын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг	Үйлдвэр, худалдаа, үйлчилгээний хүрээнд хяналт шалгалт хийх, мэргэжлийн сургалт семинар, зөвлөлгөөн зохион байгуулах, мэдээлэл сурталчилгаа явуулах	6 сая.төг
4	Монголын оюутны холбоо	Оюутны хөдөлгөөний бирж ажиллуулж, оюутнуудыг чөлөөт цагаар нь хөдөлмөр эрхлүүлэх ажлыг зохион байгуулах	4 сая 726 мян.төг
		БҮГД	16 САЯ 526 МЯН.ТӨГ